



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДАРХАН-УС СУВАГ” ХК-ИЙН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2026/1/НА-СТА-ОНА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



**Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Э.Одгэрэл

Утас: 70373089 Цахим хаяг: Odgerele@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2026 он

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАБ	Хөдөлмөр аюулгүй байдал
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ШТМ	Шатах тослох материал



"ДАРХАН-УС СУВАГ" ОНӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.ГАНЗОРИГ
ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13

№ 179

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дархан-Ус суваг" ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд өөрийн хөрөнгөөр 200,332.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга, биет бус хөрөнгө худалдан авч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

452F050292

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлого болох цэвэр усны борлуулалт 2,037.8 м/м3 борлуулахаас гүйцэтгэлээр 2,132.2 м/м3 ус борлуулж 104.6 хувь, бохир ус 2,334.2 м/м3 татан зайлуулахаас гүйцэтгэлээр 2,218.9 м/м3 буюу 95.1 хувьтай байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 29 зорилт, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 85.9 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	15,752,228.17	128,674,371.81
1.1.2	Дансны авлага	699,671,312.32	973,805,093.72
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	6,789,004.29	80,725,252.64
1.1.6	Бараа материал	381,084,559.46	426,478,191.10
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	345,949,910.00	363,964,326.00
1.1.10	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,449,247,014.24	1,973,647,235.27
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	60,000,783,299.31	55,681,607,288.98
1.2.2	Биет бус хөрөнгө	11,314,997,347.67	11,329,001,355.08
1.2.3	Биологийн хөрөнгө	1,600,000.00	1,600,000.00
1.2.9	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	71,317,380,646.98	67,012,208,644.06
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	72,766,627,661.22	68,985,855,879.33
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	378,356,652.26	120,516,894.67
2.1.1.2	Цалингийн өглөг	135,745,553.34	175,397,242.18
2.1.1.3	Татварын өр	286,969,536.80	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	11,336,371.98	16,721,810.24
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	26,801,871.57	25,624,336.36
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр		
2.1.1.12	Богино хугацаат өр төлбөрийн дүн	839,209,985.95	338,260,283.45
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	39,559,240,699.31	39,358,908,337.31
2.1.2.5	Урт хугацаат өр төлбөрийн дүн	39,559,240,699.31	39,358,908,337.31
2.2	Өр төлбөрийн нийт дүн	40,398,450,685.26	39,697,168,620.76
	Эздийн өмч		
2.3	Өмч:	3,384,431,409.00	3,384,431,409.00
2.3.1	- төрийн	3,384,431,409.00	3,384,431,409.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,609,461,293.02	11,609,461,293.02
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	39,815,363,579.82	39,910,271,222.11
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(22,441,079,305.88)	(25,615,476,665.56)
2.3.10	Эздийн өмчийн дүн	32,368,176,975.96	29,288,687,258.57
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	72,766,627,661.22	68,985,855,879.33

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	10,933,051,262.88	12,420,428,409.11
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	10,161,777,581.98	12,568,256,096.68
3	Нийт ашиг (алдагдал)	771,273,680.90	(147,827,687.57)
8	Бусад орлого	625,629,367.88	457,172,270.90
9	Борлуулалт, маркетингийн зардал	995,406,420.02	988,050,471.24
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,484,634,010.67	1,549,621,847.78
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	1,497,614,134.49	946,069,623.99
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(1,077,023.20)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,581,828,539.60)	(3,174,397,359.68)
19	Орлогын татварын зардал		
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(2,581,828,539.60)	(3,174,397,359.68)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,581,828,539.60)	(3,174,397,359.68)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 01 -р сарын 01 - ний үлдэгдэл	3,384,431,409.00	11,609,461,293.02	36,879,239,437.22	(19,859,250,766.28)	32,013,881,372.96
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө,	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	3,384,431,409.00	11,609,461,293.02	36,879,239,437.22	(19,859,250,766.28)	32,013,881,372.96
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(2,581,828,539.60)	(2,581,828,539.60)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	2,936,124,142.60	-	2,936,124,142.60
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2024 оны 12 -р сарын 31 - ний үлдэгдэл	3,384,431,409.00	11,609,461,293.02	39,815,363,579.82	(22,441,079,305.88)	32,368,176,975.96
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	3,384,431,409.00	11,609,461,293.02	39,815,363,579.82	(22,441,079,305.88)	32,368,176,975.96
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(3,174,397,359.68)	(3,174,397,359.68)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	94,907,642.29	-	94,907,642.29
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
17	2025 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	3,384,431,409.00	11,609,461,293.02	39,910,271,222.11	(25,615,476,665.56)	29,288,687,258.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант үеийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн	12,874,909,428.34	14,178,845,752.72
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	12,415,195,689.65	14,145,999,149.08
1.1.6	Бусад мөнгөн орлого	459,713,738.69	32,846,603.64
1.2	Мөнгөн зарлагын дүн	12,955,687,124.17	13,865,591,247.08
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,969,164,475.31	4,197,285,805.40
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,254,060,314.00	1,308,171,357.33
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	5,479,798,994.70	5,987,248,707.02
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	25,382,794.50	14,020,931.49
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,732,183,447.97	1,886,183,545.12
1.2.9	Бусад мөнгөн зарлага	495,097,097.69	472,680,900.72
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(80,777,695.83)	313,254,505.64
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	200,332,362.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		200,332,362.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(200,332,362.00)
3.1	Мөнгөн орлогын дүн	630,000,000.00	500,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	630,000,000.00	500,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	630,000,000.00	500,000,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	630,000,000.00	500,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(80,777,695.83)	112,922,143.64
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	96,529,924.00	15,752,228.17
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,752,228.17	128,674,371.81

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Зардлын нэр	2025 он			
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
ОРЛОГО					
1	Усны борлуулалтын орлого	12,525,514,527.96	12,420,428,409.70	(105,086,118.25)	99.2
2	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	432,428,210.51	457,172,270.55	24,744,060.04	105.7
ОРЛОГЫН ДҮН		12,957,942,738.47	12,877,600,680.25	(80,342,058.21)	99.4
1	Цалин	5,316,638,137.66	4,862,667,864.96	(453,970,272.70)	91.5
2	НДШимтгэл	774,550,216.91	664,009,994.89	(110,540,222.02)	85.7
3	Албан томилолт	106,460,172.73	27,317,208.44	(79,142,964.29)	25.7
4	Автын сэлбэг	117,777,473.46	108,839,155.17	(8,938,318.29)	92.4
5	Усан хангамж, ариутгах	570,583,078.65	491,820,580	(78,762,499)	86.2
6	Цахилгааны сэлбэг	110,637,981.03	81,687,603.51	(28,950,377.52)	73.8
7	Барилгын материал	79,166,534.18	70,522,883	(8,643,651)	89.1
8	Аж ахуйн материал	172,474,961.08	176,134,906.04	3,659,944.96	102.1
9	хүнсний материал	5,582,772.73	8,042,279.95	2,459,507.22	144.1
10	Багаж хэрэгсэл	26,808,409.49	80,638,949	53,830,540	300.8
11	Цэвэрлэгээний материал	13,456,761.55	12,596,243.60	(860,517.95)	93.6
12	Шуудан холбоо	53,277,749.38	51,602,235.36	(1,675,514.02)	96.9
13	ШТМ	501,041,265.23	387,267,118.57	(113,774,146.66)	77.3
14	Үндсэн хөрөнгийн элэгдэл	5,553,804,696.30	5,484,604,990.52	(69,199,705.78)	98.8
15	Бичиг хэрэг	35,003,427.81	42,746,567.31	7,743,139.50	122.1
16	Ус	14,558,578.57	24,954,382.56	10,395,803.99	171.4
17	Дулаан	63,935,101.20	53,297,111.45	(10,637,989.75)	83.4
18	Цахилгаан	1,257,967,423.74	1,172,625,264.28	(85,342,159.00)	93.2
19	Хоол, унаа	345,801,000.00	336,958,000.00	(8,843,000.00)	97.4
20	Хөдөлмөр хамгаалал	257,379,711.49	273,437,428.33	16,057,716.84	106.2
21	Шагнал урамшуулал	-	-	-	-
22	Сургалт	37,744,950.00	13,891,313.64	(23,853,636.36)	36.8
23	Нөхөн сэргээлт	149,815,976.20	117,757,604.10	(32,058,372.10)	78.6
24	Аваарын хоол	31,685,827.29	20,653,440.94	(11,032,386.35)	65.2
25	Гамшиг, нөөц сангийн	5,363,636.36	5,486,835.41	123,199.05	102.3
26	Бусдаар гүйцэтгүүлэх	396,646,137.17	376,415,598.87	(20,230,538.30)	94.9
27	Зар сурталчилгаа	18,743,750.00	22,181,818.18	3,438,068.18	118.3
28	Хамгаалах салаа	71,301,536.25	65,333,209.16	(5,968,327.09)	91.6
29	Зээлийн хүүгийн зардал	41,570,260.71	14,020,931.49	(27,549,329.22)	33.7
30	Зохицуулах үйлчилгээний	73,559,338.10	73,482,530.00	(76,808.10)	99.9
31	Татвар	78,402,897.16	38,027,366.19	(40,375,530.97)	48.5
32	хэлэлцүүлгийн зардал	1,962,860.03	962,860.03	(1,000,000.00)	49.1
33	Даатгалын зардал	30,287,430.83	26,583,082.79	(3,704,348.04)	87.8
34	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,272,832,542.62	946,069,623.90	(326,762,918.72)	74.3
БАЙГУУЛЛАГЫН НИЙТ ЗАРДАЛ		17,586,822,595.90	16,051,998,040.99	(1,534,824,554.45)	91.3
АШИГ, АЛДАГДАЛ		(4,628,879,857.43)	(3,174,397,359.68)	1,454,482,497.75	68.6

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 93,712.8 мянган төгрөгийн, зөрчил¹ илрүүлж 320.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 93,392.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

- Тайлант онд бизнес төлөвлөгөөнд тусгаагүй удирдах зөвлөлийн гишүүдийн хоолны зардлыг санхүүжүүлж үр ашиггүй зардал гарсан байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.1-д “хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;”, 84.4.2-д “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт ТОГТООВ.

5.2 Зөвлөмж

5.2.1. Зардлын данстай холбоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: 1

Тайлант онд ном хэвлүүлэх, видео контент хийх, тэмцээн уралдааны зардалд нийт 82,635.3 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д “Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл хийх зардлыг санхүүжүүлэхгүй, үр ашиггүй зардал гаргахгүй байх.

Илрүүлэлт: 2

Тайлант онд бусад байгууллагын ойн арга хэмжээний шагналын зардалд нийт 1,200.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг;” олгохгүй, үр ашиггүй зардал гаргахгүй байх.

Илрүүлэлт: 3

Тайлант онд зардлыг төлөвлөсөн хэмжээнээс нийт 9,557.5 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.1-д “хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хууль, Компанийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, зардлыг төлөвлөсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд баярын хурал, тэмцээн уралдаан зохион байгуулах, хүлээн авалт, баримтат кино хийх зардлыг санхүүжүүлсэн байна	1	82,635.3					1	82,635.3				
Байгууллагын хөрөнгөөр бусад байгууллагын ойн арга хэмжээний шагналд зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан байна.	1	1,200.0					1	1,200.0				
Бизнес төлөвлөгөөнд тусгаагүй удирдах зөвлөлийн гишүүдийн хоолны зардлыг санхүүжүүлж үр ашиггүй зарцуулсан байна.	1	320.0	1	320.0								
Зардлыг төлөвлөсөн хэмжээнээс хэтрүүлсэн байна.	1	9,557.5					1	9,557.5				
Дүн	5	93,712.8	1	320.0			3	93,392.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хөрөнгө гаргах 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	34,232.9	-	-	-	-	1	34,232.9
Дүн	1	34,232.9	-	-	-	-	1	34,232.9